

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2018.12.26

дугаар

Улаанбаатар хот

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2018 оны 12 дугаар сарын 26 -ны өдрийн 13 цагаас Улаанбаатар зочид буудлын хурлын танхимд хуралдав.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирсэн саналын хуудсаар хуралд оролцогчдын ирцийг тооллогын комисс нэгтгэн гаргаж “хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай” ХЭХ-ын тооллогын комиссын тогтоолыг комиссын дарга /М.Мөнхболор/ уншиж танилцуулав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт 10,170,242 ширхэг саналын эрхтэй хувьцааг төлөөлж 9,615,324 ширхэг энгийн хувьцаа бүгд 94.54 хувь болсныг мэдээлж, компанийн тухай хуулийн 69.1 дэх заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 4-ийн 7 дахь заалтын дагуу энэхүү ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг уг тогтоолд дурьдсан байна.

Хурлыг нээж хурлын дарга Ө.Хишигсүх үг хэлэв.

Ө.Хишигсүх –Тус компанийн 2018.11.14-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахаар зохих шийдвэрийг гаргасан. ТУЗ-ийн гишүүн Казин Ник чөлөөлөгдөх хүсэлт гаргасантай холбогдуулан тус компанийн 10 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан, ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинэ гишүүн сонгуулах санал бүхий шаардлага ирүүлсэнтэй холбогдуулан, Компанийн тухай хуулийн 62.1.7, компанийн дүрмийн 7.7.2 дахь заалтыг тус тус үндэслэн, мөн Компанийн тухай хуульд заасан шаардлагын дагуу нэг гишүүнийг дангаар нь сонгох боломжгүй, ТУЗ-ийн гишүүдийг бүрэлдэхүүнээр нь шинээр батлах тул энэхүү ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэр гарсныг мэдээлж байна.

Компанийн тухай хуулийн 69.1-д “Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно” гэсэн заалттай.

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын компанийн нийт 10,170,242 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг төлөөлж 9,615,324 ширхэг саналын эрхтэй хувьцаа, бүгд 94.54 хувь болсныг мэдээлж хувьцаа эзэмшигчдийн ээлжит

бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсон тухай 01 тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үйл ажиллагааг нээснийг мэдэгдье.

Дараа нь хурлын дарга Ө.Хишигсүх хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Үүнд: Компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай” асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбогдох материалыг урьдчилан хүргүүлсэн байгаа гэв.

Хэлэлцэх үндсэн асуудал болох компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга нэр дэвшүүлэх хорооны дарга Ж.Эрдэмбилэг товч танилцуулна гэв.

Ж.Эрдэмбилэг-ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг товчхон танилцуулав.

Ө.Хишигсүх-Хэлэлцэж буй асуудалтай холбоотой үг хэлэх, санал бодлоо хэлэх хувьцаа эзэмшигчдийн үгийг сонсоё. Үг хэлэх гишүүд цаг хугацаагаа сайтар баримтлахыг хүсье гэв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай”

Б.Энхбаяр—Нэр дэвшигчдийн царайг нь харъя

Ж.Эрдэмбилэг—Хуралд нэр дэвшигчдээс 4-н хүн байна, Д.Байлхүү, Ж.Эрдэмбилэг, Б.Батмөнх, Ө.Хишигсүх нар байна. Хуулиараа заавал хуралд биеэр байлцах шаардлагагүй.

Б.Энхбаяр —Байгаа нь өөрийгөө танилцуулаач, тухайлбал шинээр томилогдсон захирал

Ө.Хишигсүх-Өөрийгөө товчхон танилцуулъя гээд, 2018 оны 6 сараас ерөнхий захирлаар ажиллаж эхэлсэн, 1979 онд ЦНДС төгссөн, ардын армид удирдах албан тушаал, мөн өөрийн Өргөө компанийг үүсгэн байгуулж ажилласан.

Б.Батмөнх-Тодруулга авъя, саналаа яаж зөв өгөх талаар гэв.

Тооллогын комиссын гишүүн Ө.Энхтайван-Кумулятив аргын талаар жишээтэй тайлбарлаж өгөв.

Ө.Хишигсүх – Асууж, ярилцах, санал бодлоо солилцох талаар ярилцлаа үүгээр үндсэн асуудлаа дуусгаад түр завсарлая. Энэ хооронд тооллогын комисс дүнгээ нэгтгэж гаргаад тогтоолоо танилцуулна гэв.

Түр завсарлав.

Хурлын тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар ирүүлсэн дүнг нэгтгэсэн тул хурал үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга М.Мөнхболор тооллогын комиссын дүн, тогтоолыг танилцуулав.

Үүнд: Нийт 22 саналын хуудас ирүүлснээс 7 саналын хуудас нь саналын эрхээсээ илүү санал өгч хуваарь зөрчсөн тул хүчингүйд тооцож, 9,613,391 ширхэг энгийн хувьцааны 15 саналын хуудас хүчинтэй тул эдгээр саналын хуудсаар өгсөн саналыг тоолж, энэхүү тооллогын комиссын тогтоол дугаар 2-ийг гаргалаа гэж уншиж танилцуулав. Үүнд:

I.	Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох	Санал өгөх эрх	Санал өгсөн эрх	Хувь
а)Ердийн гишүүд				
	Б.Батмөнх	57,680,346	13,520,415	23.44%
	Жеймс Пассин	57,680,346	7,399,159	12.82%
	Ж.Эрдэмбилэг	57,680,346	7,352,231	12.7465%
	Б.Итгэл	57,680,346	7,352,208	12.7465%
	Ө.Хишигсүх	57,680,346	7,352,131	12.7463%
	Б.Батбаатар	57,680,346	7,352,130	12.7463%
	Т.Говьдэлгэр	57,680,346	7,352,028	12.7462%
	Г.Одонтуул	57,680,346	-	0.00%
б) Хараат бус гишүүд				
	Г.Хулан	28,840,173	7,308,307	25.341%
	О.Цэндсүрэн	28,840,173	7,308,255	25.341%
	М.Батсүрэн	28,840,173	7,308,198	25.340%
	Д.Байлхүү	28,840,173	6,915,391	23.978%
	Г.Дөлгөөнтамир	28,840,173	-	0.00%

Тооллогын комиссын тогтоолоос асууж танилцах зүйл гарсангүй. /Тооллогын комиссын тогтоол дугаар 02-ыг хавсаргав/

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд хэлэлцсэн асуудалтай холбогдуулан гарах тогтоолын төслийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Батсуурь уншиж сонгов. Үүнд:

1. “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай” тогтоол №01 /тогтоолыг хавсаргав/

Хурлаас гарах тогтоолын төслийн талаар асууж тодруулах зүйл байгаа эсэхийг хурал даргалагч Ө.Хишигсүх асуухад асуулт гарсангүй.

Хурлын үйл ажиллагааг хурлын дарга Ө.Хишигсүх хааж, товч үг хэлснээр хурлын үйл ажиллагаа өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Танилцсан: Хурлын дарга



Л.Батсуурь

Ө.Хишигсүх